



TRAINAIR  
PLUS  
FULL MEMBER

# НИСЭХИЙН СУРГАЛТЫН ТӨВИЙН КАТАЛОГ

 <b>МОНГОЛ УЛС</b> <b>ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР</b> CIVIL AVIATION AUTHORITY OF MONGOLIA	
<b>ИРГЭНИЙ НИСЭХИЙН СУРГАЛТЫН</b> <b>БАЙГУУЛЛАГЫН ГЭРЧИЛГЭЭ</b> CERTIFICATE OF CIVIL AVIATION TRAINING ORGANISATION	
№ МСAA.141.05	
Байгууллагын нэр: Name of Organisation	ИНЕГ-ын Сургалтын төв Training Center of CAA of Mongolia
Бизнес хаяг: Whose business address	Монгол улс, 17120 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо, Буянт-Ухаа Buyant-Ukhaa, 10th khoroo, Khan-Uul district, Ulaanbaatar 17120, Mongolia
<p>Дээр дурдсан байгууллага нь Монголын Иргэний нисэхийн дүрэм ИНД-141-ийн шаардлагуудыг хангасан ба тус гэрчилгээний салшгүй нэг хэсэг болох "Үйл ажиллагааны тодорхойлолт"-д заагдсан сургалтыг явуулах эрхтэй.</p> <p><i>It is hereby certified that the above mentioned organization complies with the requirements of the Mongolian Civil Aviation Regulations Part 141, and is adequate to conduct trainings specified in the attached Operations Specifications which is an integral part of this Certificate.</i></p> <p>Энэхүү гэрчилгээг бусдад шилжүүлж үл болно. Түдгэлзүүлэх эсвэл хүчингүй болгосноос бусад тохиолдолд энэхүү гэрчилгээ нь доор заагдсан хугацаа хүртэл хүчинтэй.</p> <p><i>This certificate is not transferable and shall remain in force until specified date of expiry, unless sooner suspended or revoked.</i></p>	
ОЛГОСОН / ISSUED BY:	
Гарын үсэг: Signature	 Олгосон огноо: 2016.05.01 Date of Issue 01.May.2016
Олгосон албан тушаалтан: Position	Ч.Батсайхан / Үнэмлэх, гэрчилгээжүүлэлтийн хэлтсийн дарга / Batsaikhan.Ch / Director of personnel licensing /
Энэхүү гэрчилгээ нь This certificate in effect until	2021.05.01 01.May.2021 хүртэл хүчинтэй.

2019

# АЮУЛГҮЙ БАЙДАЛ, АЮУЛТАЙ АЧАА



### **ИРГЭНИЙ НИСЭХИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АЖИЛТАН БЭЛТГЭХ СУУРЬ СУРГАЛТ**

Сургалтын төрөл: Танхимын сургалт  
Сургалтын үргэлжлэх хугацаа: 2 долоо хоног /112 цаг/  
Сургалтын зорилго:

Иргэний нисэхийн аюулгүй байдлын ажилтан бэлтгэх, мэргэшүүлэх, тэдэнд эрх зүйн үндэслэл, тэдгээрийн хоорондын харилцан хамаарал, шүтэлцээг ойлгуулах, Олон улсын хүрээнд хэрэгжиж буй эрх зүйн бичиг баримттай танилцуулах, мэргэшүүлэх, тэднийг сургаж дадлагажуулах, ур чадварыг хөгжүүлэх, дээшлүүлэх, мэдлэг чадвар, дадлагатай болгоно.

Сургалтад хамрагдах албан хаагч, ажилтнууд:

- Иргэний нисэхийн аюулгүй байдлын ажилтан болохоор төлөвлөж буй хүмүүс
- Иргэний нисэхийн аюулгүй байдлын ажилтнаар томилогдоод удаагүй байгаа ажилтнууд

### **ИРГЭНИЙ НИСЭХИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ШАЛГАГЧ ХАРУУЛ НАРТ ЗОРИУЛСАН СУРГАЛТ**

Сургалтын төрөл: Танхимын сургалт  
Сургалтын үргэлжлэх хугацаа: 2 долоо хоног /72 цаг/  
Сургалтын зорилго:

Иргэний нисэхийн аюулгүй байдлын шалгагч харуул нарын бэлтгэх, мэргэшүүлэх, тэдэнд эрх зүйн үндэслэл, тэдгээрийн хоорондын харилцан хамаарал, шүтэлцээг ойлгуулах, Олон улсын хүрээнд хэрэгжиж буй эрх зүйн бичиг баримттай танилцуулах, мэргэшүүлэх, тэднийг сургаж дадлагажуулах, ур чадварыг хөгжүүлэх, дээшлүүлэх, мэдлэг чадвар, дадлагатай болгоно.

Сургалтад хамрагдах албан хаагч, ажилтнууд:

- Иргэний нисэхийн аюулгүй байдлын шалгагч харуул нар

### **ИРГЭНИЙ НИСЭХИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХАРУУЛ ШАЛГАГЧ НАРЫН ДАВТАН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

Сургалтын төрөл: Танхимын сургалт  
Сургалтын үргэлжлэх хугацаа: 7 хоног /56 цаг/  
Сургалтын зорилго:

Нисэх буудлын харуул хамгаалалтын үйл ажиллагааг зохих шаардлагын түвшинд гүйцэтгэх ажлын хүрээнд Иргэний нисэхийн аюулгүй байдлын харуул шалгагч нарыг 2 жил тутам давтан сургалтад хамруулж, иргэний нисэхийн салбарт гарч буй шинэ мэдээ, мэдээлэл ба иргэний нисэхийн аюулгүй байдлын бодлого, төлөв, чиг хандлага, аюулгүй байдлын шинэ техник, тоног төхөөрөмж, шинэ технологи, шинэлэг аргачлал ба зааварчилгаа сүүлийн сургалтаас хойш гарсан нисэхийн аюулгүй байдлын эрх зүйн баримт бичигт орсон өөрчлөлтүүдтэй танилцуулж, тэдгээрийг мэргэшүүлэх, сургаж дадлагажуулах, ур чадварыг хөгжүүлэх, дээшлүүлэхэд энэхүү сургалтын зорилго оршино.

Сургалтад хамрагдах албан хаагч, ажилтнууд:

- Нисэх буудлуудын аюулгүй байдлын харуул шалгагч нар

### **ГАЗРЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТНУУДАД ЗОРИУЛСАН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АНХАН ШАТНЫ СУРГАЛТ**

Сургалтын төрөл: Танхимын сургалт

Сургалтын үргэлжлэх хугацаа: 5 хоног /40 цаг/

Сургалтын зорилго:

Нисэх буудал дээр газрын үйлчилгээ үзүүлж буй ажилтнуудын нисэхийн аюулгүй байдлын талаар хүлээх үүрэг, хариуцлага, үүссэн аливаа нөхцөл байдалд шуурхай арга хэмжээ авч хэрэгжүүлэх, түүний ач холбогдол, агаарын хөлгийн аюулгүй байдал, тавигдаж буй аюулгүй байдлын стандарт шаардлагыг таниулах, нисэх буудлын үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, техник технологи, үйлчилгээний стандартын талаар мэдлэг, дадал, чадвар олгоно.

Сургалтад хамрагдах албан хаагч, ажилтнууд:

- Газрын үйлчилгээний ажилтнуудад

### **АГААРЫН ХӨЛГИЙН ХАМГААЛАЛТЫН АЖИЛТНУУДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН СТАНДАРТ ХӨТӨЛБӨР**

Сургалтын төрөл: Танхимын сургалт

Сургалтын үргэлжлэх хугацаа: 7 хоног /56 цаг/

Сургалтын зорилго:

Агаарын хөлгийн хамгаалалтын эргүүл, харуулаар, ажиллах ажиллагсдад нисэхийн аюулгүй байдлын тухай мэдлэг олгох, харуул хамгаалалтын үйл ажиллагааг зохих шаардлагын түвшинд гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, чадвар дадал олгоно.

Сургалтад хамрагдах албан хаагч, ажилтнууд:

- Агаарын хөлгийн хамгаалалтын ажилтнууд

### **АЮУЛТАЙ АЧАА ТЭЭВЭРЛЭХ ЗӨВШӨӨРӨЛГҮЙ АГААРЫН ТЭЭВЭРЛЭГЧИЙН АЖИЛТНУУДАД ЗОРИУЛСАН АЮУЛТАЙ АЧААНЫ СУРГАЛТ**

Сургалтын төрөл: Танхимын сургалт

Сургалтын үргэлжлэх хугацаа: 3 хоног /24 цаг/

Сургалтын зорилго

Аюултай ачаа тээвэрлэх зөвшөөрөлгүй агаарын тээвэрлэгчийн ажилтнуудад ИАТА аюултай ачааны журамд заасан зайлшгүй мэдэх шаардлагатай сэдвүүдийн дагуу үндсэн ойлголт, аюултай ачааны ачааны хязгаарлалт, зорчигч болон агаарын хөлгийн гишүүдэд авч явах зөвшөөрөлтэй аюултай ачааны жагсаалт, савлагаа, тэмдэглэгээ, шошго, болон бичиг баримт, аюултай ачааг зөв таних, харьцаж ажиллах, ачааг нуугдмал хэлбэрээр агаарын хөлөгт ачигдахаас урьдчилан сэргийлэх, аюултай ачаатай холбоотой осол зөрчлийн үед анхан шатны арга хэмжээ авах тухай мэдлэгтэй болгоно.

Сургалтад хамрагдах албан хаагч, ажилтнууд

- Аюултай ачаа тээвэрлэх зөвшөөрөлгүй агаарын тээвэрлэгчийн ажилтнуудад

## **ТЭЭВЭР ЗУУЧИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНУУДАД ЗОРИУЛСАН АЮУЛТАЙ АЧААНЫ ОНОЛЫН СУРГАЛТ**

Сургалтын төрөл: Танхимын сургалт  
Сургалтын үргэлжлэх хугацаа: 3 хоног /24 цаг/

### **Сургалтын зорилго**

Тээвэр зуучийн байгууллагуудын ажилтнуудыг ИАТА “Аюултай ачааны дүрэм”-ийн дагуу зайлшгүй мэдэх шаардлагатай сэдвүүдийн дагуу онолын мэдлэг олгож, аюултай ачааг зөв таних, зөв харьцаж ажиллах, дүрмийн дагуу тээвэрлэлтэд бэлтгэх, савалгаа болон бичиг баримтыг зөв бэлтгэх, аюултай ачааг нуугдмал хэлбэрээр агаарын хөлөгт тээвэрлэгдэхээс урьдчилан сэргийлэх болон аюултай ачаатай холбоотой осол зөрчлийн үед анхан шатны арга хэмжээ авах тухай мэдлэгтэй болгоно.

Сургалтад хамрагдах албан хаагч, ажилтнууд  
- Тээвэр зуучийн байгууллагын ажилтнууд

## **АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АЖИЛТНУУДАД ЗОРИУЛСАН АЮУЛТАЙ АЧААНЫ ОНОЛЫН СУРГАЛТ**

Сургалтын төрөл: Танхимын сургалт  
Сургалтын үргэлжлэх хугацаа: 3 хоног /24 цаг/

### **Сургалтын зорилго**

Аюулгүй байдлын ажилтнуудыг ИАТА Аюултай ачааны журмын дагуу зайлшгүй мэдэх шаардлагатай сэдвүүдийн дагуу онолын мэдлэг олгож, аюултай ачааг зөв таних, харьцаж ажиллах, аюултай ачааны хязгаарлалт, ачааг нуугдмал хэлбэрээр агаарын хөлөгт ачигдахаас урьдчилан сэргийлэх болон аюултай ачаатай холбоотой осол зөрчлийн үед анхан шатны арга хэмжээ авах тухай мэдлэгтэй болгоно.

Сургалтад хамрагдах албан хаагч, ажилтнууд  
- Аюулгүй байдлын ажилтнууд